



ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН САНХҮҮГИЙН НЭГДСЭН ТАЙЛАН

2013 он

Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан Аймгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

Лавлах зүйлс байвал доорх хаягаар

холбоо барина уу:

Аймгийн Ерөнхий Аудитор

Л.Жаргалсайхан

Утас: 70272582

И-мэйл

Аудитын менежер

О.Амаржаргал

Утас: 70273463

И-мэйл

Аудитор

О.Сосор

Утас: 70273204

И-мэйл

АГУУЛГА

ХУУДАС

• Танилцуулга	1-7
• Санхүүгийн дотоод хяналт	7
• Гол шийдлүүд	8
• Залруулаагүй алдаа	8
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	8
• Аудитын санал дүгнэлт	8-

ТӨАГ-ын хаягийг оруулах

Төв аймаг Зуунмод сум 1-р баг Төрийн
байгууллагуудын ордон

Төв аймгийн Заамар сумын 2013 оны санхүүгийн нэгдсэн тайланд ААГ аудит хийж дууссан тухай мэдэгдэл

Бид Төв аймгийн Заамар сумын 2013 оны нэгдсэн санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба Заамар сумын төсвийн ерөнхийлөн захирагчид энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Заамар сумын Удирдлага тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирдлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

- Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг **тодруулбал:**

НББ-ийн үе шат бүрд дээд шатны түвшний удирдлага хүрдэг эсэх, нийтлэг чанартай зардал, төсвийн санхүүжилт, өөрийн орлого, цалингийн зардал, өглөг, авлага, балансын үзүүлэлтүүд, үндсэн хөрөнгө, бараа материал, бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

- Гол илрүүлсэн зүйлс аудитын үр дүнгээс гарсныг **тодруулбал:**

- Мөнгөн харилцахын журналаас sort filter –ийг ашиглан эх үүсвэрийг тайлан тэнцэлд тусгасаныг шалгахад мөнгөн гүйлгээний тайланд орлого, санхүүжилтийг бүрэн тусгасан байна.

- МГТайланд НД-ийн байгууллагаас ирсэн листний 18058.9 мянган төгрөгийг орлого эх үүсвэр болон зарлагыг нэмэгдүүлэн тайлагнасан байсныг аудитын явцад залруулсан.

-Хог хаягдлын үйлчилгээний хураамж 2180.0 мянган төгрөгийг орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлэлгүй иргэн Рагчаагийн нэрийн дансанд шилжүүлэн зарцуулж байгаа нь Төсвийн тухай хуулийн 23.8-д сум дүүргийн татварын орлогод хог хаягдлын үйлчилгээний хураамж орохоор заасан заалтыг зөрчсөн байна.

- - Орон нутгийн хөгжлийн сангаас ард иргэдийн саналыг авч эрэмбэлэгдсэн жагсаалтад ороогүй 62660.4 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 60-р зүйлийн 60.3.6-д орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн

төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал,
арга хэмжээнд Орон нутгийн
хөгжлийн сангийн хөрөнгийг
зарцуулахыг хориглоно гэсэн заалтыг
зөрчсөн байна.

-ЕМ, Санхүүгийн албаны даргаас ААГ
тайлбар мэдүүлэг хүлээж байгаа

-Илэрсэн алдааг хэрхэн залруулсан
талаар тайлбар ирүүлнэ үү

Санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил
илэрээгүй тул Зөрчилгүй санал дүгнэлт
гаргахаар Ерөнхий аудиторт санал
оруулсан байгаа.

Аймгийн Ерөнхий Аудитор 2014 оны 03-р
сарын 24-ны өдөр санал дүгнэлтэнд гарын
үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад Ахлах нягтлан
бодогч Ч.Бүдсүрэн олон бусад бидэнтэй
хамтран ажилласан ажиллагсдын байнгын
дэмжлэг туслалцаа бидний ажилд дэмжлэг
болж байсанд гүнээ талархаж байна.

Аудитор О.Сосор

Төв аймгийн Аудитын Газар

2014.03.24

Танилцуулга

1. Бид Төв аймгийн Заамар сумын 2013 оны 12 дугаар сарын 31-р тасалбар болсон нэгдсэн санхүүгийн тайланд аудитаа хийж дуусаж байгаа ба санхүүгийн нэгдсэн тайланд ЗДТГ, Баг, ИТХурал, Сургууль, Цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төв, Мал хамгаалах сан, Сум хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах сан, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, Эргэлтийн эмийн сангийн тайлангууд нэгтгэгдсэн байна. Заамар сумын удирдлагад энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Заамар сумын удирдлага тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Жилийн санхүүгийн тайланд аудит хийх.

2. ААГ санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь Заамар сумын хяналтыг ААГ-ын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм. Заамар сумын тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.

3. Дараахь түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Заамар сумын удирдлагын анхаарлыг хандуулж байна.

Орлого, санхүүжилтийн талаар

Орлого санхүүжилтыг тайлан тэнцэлд бүрэн тусгасныг тулган шалгасан.

Мөнгөн харилцахын журналаас sort filter –ийг ашиглан эх үүсвэрийг тайлан тэнцэлд тусгасаныг шалгахад мөнгөн гүйлгээний тайланд орлого, санхүүжилтийг бүрэн тусгасан байна.

Сумын ИТХурлын 2012.12.20 ны өдрийн 04 тоот тогтоолоор 2013 оны орон нутгийн орлогыг 27185.6 мянган төгрөгөөр батласан. 2013.12.20 ны өдрийн 04 тоот тогтоолоор орлогыг 14000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 41185.6 мянган төгрөгөөр баталсан. Гүйцэтгэлээр орон нутгийн орлогын дансанд 79583.9 мянган төгрөг төвлөрч орлогын төлөвлөгөө 38398.3 мянган төгрөг буюу 193.2 хувиар биелсэн байна.

Сумын ИТХурлын 2012.12.20 ны өдрийн 04 тоот тогтоолоор 2013 оны орон нутгийн төсвийн зарлагын нийт дүнг баталсан. Үүнд ИТХурал-40077.7 мянган төгрөг, Баг, ЗДТГ-г 285616.3 мянган төгрөг, нийгмийн халамжийн сан- 464924.0 мянган төгрөг, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардал-12000.0 мянган төгрөгөөр, тусгай шилжүүлгийн дүн-2005563.5 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангаар зарцуулах хөрөнгийн хэмжээг 246100.0 мянган төгрөгөөр тус тус баталсан байна.

2013 онд НЕҮйлчилгээнд төсвийн санхүүжилт 295197.6 мянган төгрөг, орон нутгийн орлогоос 96933.8 мянган төгрөг, өөрийн орлого 1411.4 мянган төгрөг, нийт 393543.1 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэн зарцуулсан байна.

Тусгай зориулалттай шилжүүлгээр 12 жилийн сургуульд 701488.2 мянган төгрөг, Шижир алт сургуульд 420844.5 мянган төгрөг, төвийн цэцэрлэгт 204857.6 мянган төгрөг, Шижир-алт цэцэрлэгт 260549.1 мянган төгрөг, Орос цэцэрлэг 21790.0 мянган төгрөг, Эмнэлэгт 285148.2 мянган төгрөг, Соёлын төвд 67300.4 мянган төгрөг, нийт 1961978.0 мянган төгрөгийн эх үүсвэрийг нэгтгэсэн байна.

Халамжийн сангийн санхүүжилт 300382.0 мянган төгрөг төгрөгийг халамж үйлчилгээний санд төвлөрүүлснээс халамжийн тэтгэвэрт 197690.3 мянган төгрөг, жирэмсэн амаржсан эхийн тэтгэмжинд 89486.7 мянган төгрөг, хоол тэжээлийн тусламж дэмжлэгт 12490.0 мянган төгрөг, хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж 685.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн дансны санхүүжилтээр ЗДТГазарт 38722.7 мянган төгрөг, Сургууль 3138.0 мянган төгрөг, Шижир-алт сургууль 1943.0 мянган төгрөг, Соёлын төв 14106.8 мянган төгрөг, Цэцэрлэг 20000.0 мянган төгрөг, Эмнэлэг 3228.4 мянган төгрөг, нийт 81139.0 мянган төгрөгийн орлого орж, 81139.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж оны эцэст үлдэгдэлгүй мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд нэгтгэсэн.

Төсөвт байгууллагын өөрийн орлогоор ЗДТГ-т 1411.7 мянган төгрөг, Соёлын төв 1250.0 мянган төгрөг, эмнэлэгт 516.5 мянган төгрөг, нийт 3178.2 мянган төгрөг нэгтгэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө

Сумын нэгдсэн тайлангаар Үндсэн хөрөнгийн данс нь оны эхэнд 6072280.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 1051258.4 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 138501.1 мянган төгрөгийн хөрөнгө хасагдаж, жилийн эцэст 6985039.9 мянган төгрөгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна. Тайлант онд байгуулсан үндсэн хөрөнгийн элэгдэл 205029.5 мянган төгрөг, үлдэх өртөг 4325224.7 мянган төгрөг байна. Сумын ИТХ-н 2013.12.05-ний өдрийн 03 тоот тогтоолоор нийт **133501.1** мянган төгрөгний үндсэн хөрөнгө акталж устгасан.

Бараа материал

Бараа материалын үлдэгдэл оны эхэнд 170713.5 мянган төгрөг, тайлант онд 355914.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, 328322.6 мянган төгрөг зарцуулж, оны эцэст 198305.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй нэгтгэгдсэн байна.

Мөнгөн хөрөнгө

Сумын нэгдсэн тайлангаар оны эхэнд орон нутгийн орлогын данс 50586.7 мянган төгрөг, ЗДТГазар 15884.6 мянган төгрөг, Баг 4348.5 мянган төгрөг, нийт 20233.1 мянган төгрөг, Тусгай зориулалтийн сангууд 84188.9 мянган төгрөг, Орон нутгийн орлогын данс 24607.0 мянган төгрөг, эм эргэлтийн сан 7267.7 мянган төгрөг, нийт 162276.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан.

Жилийн эцсийн байдлаар Тусгай зориулалтийн сангууд 49098.4 мянган төгрөг, Орон нутгийн орлогын данс 13236.8 мянган төгрөг, эм эргэлтийн сан 3684.9 мянган төгрөг, нийт 66020.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй нэгтгэгдсэн байна. Энэ Төрийн сангийн

төлөөлөгчийн ирүүлсэн үлдэгдлийн баталгаагаар болон ХААН банкнаас ирүүлсэн эм эргэлтийн сангийн үлдэгдлийн баталгаагаар тохирч байна.

Мөнгөн хөрөнгийн тайлан гаргалт анхан шатны баримтын бүрдлийг хэсэгчлэн шалгахад мөнгөн хөрөнгөнд хөтлөгдөх анхан шатны баримтыг зохих журмын дагуу бүрдүүлсэн байна.Төрийн сангаас гүйлгээ хийсэн баримт бүрт төрийн сангийн тэмдэг дарж баталгаажуулсан байна.

Орон нутгийн орлогын дансны эхний үлдэгдэл 50586.7 мянган төгрөг,тайлант онд орон нутгийн орлогоор 79583.9 мянган төгрөгийн орлого орсон байна. Орлогын данснаас НЕҮйлчилгээнд 96933.9 мянган төгрөг, төвийн цэцэрлэгт 20000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож , дансны үлдэгдэл 13236.8 мянган төгрөгийг ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн.

НЕҮйлчилгээний байгууллагууд /ЗДТГ 9075.3 мянган төгрөг, Баг -1014.4 мянган төгрөг, ИТХурал-104.3 мянган төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжсэн улсын төсвийн байгууллагууд /Цэцэрлэгүүд-826.0 мян.төгрөг, ЕБСургуулиуд -4848.4 мян.төгрөг, / -5674.4 мянган төгрөгийг тус тус төсөвт төвлөрүүлсэн байна. Орон нутгийн нэгдсэн санхүүгийн тайланд 2013 оны 12-р сарын 31-ний байдлаар орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл 13236.8 мянган төгрөг, тусгай зориулалтын сангуудын үлдэгдэл -49098.4 мянган төгрөг,эм эргэлтийн сангийн үлдэгдэл-3685.0 мянган төгрөг, нийт 66020.2 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй нэгтгэгдсэн нь төсөвт байгууллагуудын тайлан тэнцлийн дүнтэй тохирч байна.

Авлага ,өглөгийн талаар

Авлага өглөгийн журналыг ерөнхий дэвтрийн данстай тулган баталгаажуулсан.

Ажил гүйлгээг тухай бүрд нь өглөг, авлага үүсгэн бүртгэсэн. 2013 оны жилийн эцсийн нэгдсэн санхүүгийн тайланд авлага оны эхэнд 125915.6 мянган төгрөг, жилийн эцэст 255976.8 мянган төгрөг болж авлага оны эхнээс 130061.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийт авлагын 253319.1 мянган төгрөг буюу 98.9 хувийг сум хөгжүүлэх сангаас олгосон зээл болон зээлийн хүүгийн авлага эзэлж байна.

Өглөг оны эхэнд 4943.9 мянган төгрөг, тайлант онд 7573.7 мянган төгрөгөөр нэмэгдэж, оны эцэст 12517.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.Ану сервис ХХК-д өгөх халаалтын өглөг 11307.7 мянган төгрөг буюу нийт өрийн 90.3 хувийг эзлэж байна.

Тусгай зориулалтын сангуудын талаар

ГХУС сангийн эхний үлдэгдэл 1532.7 мянган төгрөг, тайлант онд 6839.7 мянган төгрөгийн санхүүжилт хийгдэж, эрх зүйн сургалт суртчилгаанд-1024.1мянган төгрөг,нийтийг хамарсан арга хэмжээнд 1132.6 мянган төгрөг,Олон нийтийн байцаагч хайлаас, төвийн багуудад ажиллуулж сард 140400 төгрөгийн урамшил олгож нийт 3649.3 мянган төгрөг,хурал семинарт 711.6 мянган төгрөг, нийт 6702.7 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 1669.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Сурагчдын бүлгийн хувцас, цоож, номны үнэнд 885.0 мянган зарцуулсан байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19.4-т Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно

гэсэн заалтыг зөрчиж 885.0 мянган төгрөгөөр бараа материал авахад зарцуулсан байна.

Мал хамгаалах сангийн эхний үлдэгдэл-3000.0 мянган төгрөг, тайлант онд гүйлгээ гараагүй, оны эцэст 3000.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Байгаль хамгаалах сангийн оны эхний үлдэгдэл 260.5 мянган төгрөг, тайлант онд аймгаас санхүүжилт 12000.0 мянган төгрөг, байгал орчныг цэвэрлэхэд хандиваар -2900.0 мянган төгрөг, морин эргүүл 200.0 мянган төгрөг, МЖРесурс ХХК нөхөн сэргээлт-200.0 мянган төгрөг, Нью хаппу ХХК-200.0 мянган төгрөг, Алтан дорнод монгол ХХК-415.2 мянган төгрөг, Бумбат ХХК-1948.4 мянган төгрөг, нийт нөхөн сэргээлтийн 2763.6 мянган төгрөгийг байгаль хамгаалах санд төвлөрүүлсэн байна. Зарцуулалтыг авч үзвэл хогийн цэвэрлэгээнд 8963.0 мянган төгрөг, нохой устгалд 4657.0 мянган төгрөг, мод суулгацийн үнэ -350.0 мянган төгрөг, хогийн цэгийн сахиулын цалинд 639.3 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна. Оны эцэст 6019.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Орон нутгийн хөгжлийн сан. Заамар сумын ИТХурлын 2013 оны 05-р сарын 30 ны өдрийн 01 тоот тогтоолоор сумын орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулах үндсэн зарчмын баримталж үр ашгийг аль болох олон иргэд хүртэх цаашид үр ашиг нь үргэлжлэх байдлыг харгалзан хөрөнгө оруулалтын чиглэлээр эрэмбэлсэн 18 ажлын жагсаалтыг 246100.0 мянган төгрөгөөр батласан байна.

2013 онд орон нутгийн хөгжлийн санд 173362.4 мянган төгрөгийн санхүүжилт, сумын 90 жилийн хандив ААНэгж, иргэдээс 25053.5 мянган төгрөг, нийт 198715.9 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлсэн байна. Зарцуулалтыг гүйцэтгэсэн ажлаар нь задлавал

- Наадмын талбайн зүлэгжүүлэлт, засвар 37943.7 мянган төгрөг
- Сумын төв талбайн зүлэгжүүлэлт, тохижилт 57532.9 мянган төгрөг

Халуун ус 2000.0 мянган төгрөг, төвийн цэцэрлэгийн тохижилт 9498.0 мянган төгрөг, ЭМТөвийн тохижилт 5270.0 мянган төгрөг, нийт 110244.6 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлууд нь ИТХурлын тогтоолд заагдсан ажлуудад зарцуулсан байна.

Наадмын талбайн зүлэгжүүлэлт 5900.0 мянган төгрөг, сумын төвийн талбайн зүлэгжүүлэлт 7800.0 мянган төгрөгийн ажлыг Хуримтын Хөндий ХХК, Наадмын талбайн засварыг Галтбадрах ХХК-32043.7 мянган төгрөгөөр, Гэрэлтүүлэгийн 13600.0 мянган төгрөгийн ажлыг Санко Соолар ХХК- хийж гүйцэтгэсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангаас ард иргэдийн саналыг авч эрэмбэлэгдсэн жагсаалтад ороогүй 62660.4 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 60-р зүйлийн 60.3.6-д орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээнд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зарцуулахыг хориглоно гэсэн заалтыг зөрчсөн байна.

- Наадмын зардал 4738.0 мянган төгрөг
- Бохирын шугам тавихад 1730.0 мянган төгрөг
- Засаг дарга, ИТХурлын дарга нарын өрөөний засварт 8625.0 мянган төгрөг
- Сургуулийн хашаа шинэчлэхэд 28480.0 мянган төгрөг
- Баян булгийн ваннын засвар 15509.3 мянган төгрөг
- Маршрутын самбар 2085.0 мянган төгрөгийн тогтоолд заагдаагүй ажилд зарцуулсан байна.

Тайлант хугацаанд төвлөрсөн төсвөөс санхүүжилт-173362.4 мянган төгрөгийн санхүүжилт, хандиваар 25053.5 мянган төгрөг, нийт 198415.9 мянган төгрөг орж 192787.0 мянган төгрөгийг зарцуулж 5628.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн дансны оны эхний үлдэгдэл 78869.9 мянган төгрөг, тайлант онд 172000.0 мянган төгрөгийн урсгал төсвийн санхүүжилт, зээл-10637.8 мянган төгрөг, зээлийн хүүгийн орлогод 2324.5 мянган төгрөг, нийт 184962.3 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлсэн. Тайлант онд 229192.7 мянган төгрөгийн зээл олгож, оны эцэст 34639.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Зээлийн авлага 56 иргэнээс авах 243776.6 мянган төгрөгийн зээл, 9422.5 мянган төгрөгийн хүүгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Алтан заамар сангийн эхний үлдэгдэл 525.6 мянган төгрөг, тайлант онд 73893.0 мянган төгрөгийн орлого орж 73772.8 мянган төгрөг зарцуулж, оны эцэст 645.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Эргэлтийн эмийн сан. Эхний үлдэгдэл 7267.7 мянган төгрөг, тайлант онд борлуулалт болон худалдан авагчаас орсон мөнгө -12270.0 мянган төгрөг орж 15852.7 мянган төгрөгийг зарцуулж 3685.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тохижилт үйлчилгээнд-5001.0 мянган төгрөг, эм бараа материал авахад-8368.3 мянган төгрөг, урамшилд 698.2 мянган төгрөг, шатахуунд 391.6 мянган төгрөг, шуудан холбоонд 82.5 мянган төгрөгийг зарцуулсан.

Тусгай зориулалтын нийт сангуудын оны эцсийн үлдэгдэл-52783.4 мянган төгрөгөөр тайлагнасан нь тайлан тэнцлийн дүнтэй тохирч байна.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

5. Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

6. Эдгээр асуудлуудыг ААГ болон Заамар сумын удирдлага авч үзэж хангалттайгаар шийдсэн. Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрөхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Залруулагдаагүй алдаа

7. Аудитын стандарт нь ААГ-г аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Аудитаар залруулаагүй алдаа гараагүй болно.

Тайлбар мэдүүлгийн захидал

8. Аудитын үйл явцад ААГ хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ санхүү бүртгэлийн ажилтанаас эдгээр баталгааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Аудитын санал дүгнэлт

9. Аймгийн Аудитын газраас тус тайланд **зөрчилгүй** санал дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

Аймгийн Аудитын газар

2014.03.25